



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар Д/651

Хэрлэн сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Чингис хотод зохион байгуулах нэгдсэн шинэ жилийн арга хэмжээнд зориулж, урлаг соёлын үйлчилгээнд 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ